

## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРМИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАРЫГ БАТЛУУЛАХ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

- **ИНД-ийн нэр томьёоны тайлбарыг боловсруулах хууль, эрх зүйн үндэслэл, шаардлага:**

Иргэний нисэхийн үйл ажиллагаанд ашигладаг нийтлэг нэр томьёо болон товчлолын нэгдсэн ойлголтыг дараах эрх зүйн баримт бичгээр шаардсан ИНД-ийг тайлбарлан унших зорилгоор шинээр боловсруулсан. Үүнд:

- “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичгийн 2.1.2 дахь заалт “...**Чикагогийн конвенцийн Хавсралтуудын стандарт, зөвлөмжийн шаардлагад нийцүүлэн** ... Иргэний нисэхийн багц дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулна”;
- Иргэний нисэхийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө”, 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт “**Чикагогийн конвенцийн Хавсралтуудад нийцсэн** аюулгүй ажиллагааны стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах...”, 11 дүгээр зүйлийн 11.2.1-11.2.15 дахь заалт;
- ИКАО-гийн Док. 9734-ийн А Бүлэг “Аюулгүй байдлын хяналтын тогтолцоо”, 3.2.1.2 дэх заалт “... **Стандарт болон зөвлөмж (SARPs)** нь иргэний нисэхийн үйл ажиллагааны цар хүрээ болон төвөгшлөөс үл хамааран, Хэлэлцэн тохирогч улсууд хэрэгжүүлэх хэрэгтэй **минимум шаардлагыг тодорхойлдог**”;

### **ИНД-1 Тодорхойлолт ба товчлолын түүх:**

ИНД-1 “Тодорхойлолт ба товчлол”-ыг анх Монгол Улсын болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 05 сарын 06-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийн дагуу Шинэ-Зеланд улсын Part-1-д үндэслэн боловсруулж, 2007 оны 10 сарын 01-ний ЗТАЖСайдын 154 дүгээр тушаалаар баталж байсан.

ИНД-1-ийн эхний өөрчлөлтийг 2010 оны 6 сарын 30-ны ЗТБХБСайдын 236 дугаар тушаалаар шинэчлэн баталсан боловч ХЗДХЯ Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгээгүй.

Гэтэл Иргэний нисэхийн ганц ч ИНД, ЗЦ, ИКАО Хавсралт болон Док-ыг Монгол Улсын стандарт болгон батлуулаагүй мөртлөө энэ бүх баримт бичгийг тайлан уншдаг үндсэн түлхүүр болох нэр томъёоныхоо тайлбарыг MSN 6409:2015 болгон өөр сайдын удирддаг төрийн өөр байгууллагаар батлуулан, үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа нь дараах хүндрэлийг үүсгэж байна.

- Чикагогийн конвенцийн Зүйл 37-гийн шаардлагыг зөрчин, ИНЕГ өөрийн зохицуулах үүрэгтэй ИНД-ийн нэр томъёоны зохицуулалтыг бусдад хууль бусаар дамжуулснаар тухайн нэр томъёотой холбоотой нислэгийн аюулгүй байдлын хариуцлага хүлээх субъектийг тодорхойгүй болгосон;
- Иргэний нисэхийн нэр томъёог тогтмол шинэчлэх шаардлагатай байдаг боловч (Монгол Улсын стандартыг шинэчлэх хугацаа 5 жил) шинэчлэж чаддаггүй болсон;
- MSN 6409:2015-ыг үндэслэн боловсруулсан ИКАО Док 9713 нь өөрөө хүчингүй болсон төдийгүй 6409:2015 нь өнөөгийн хэрэгцээ шаардлага хангахгүй болтол хоцрогдсон.

### ***ИНД-ийн нэр томъёоны тайлбарын зорилго***

ИНД-ийн нэр томъёоны тайлбар нь иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцож байгаа этгээд иргэний нисэхийн тухай хууль болон ИНД, зөвлөмжийн цуврал зэрэг эрх зүйн баримт бичгийг нэгдсэн нэг утгаар ойлгож, ашиглахад хэрэглэдэг нэр томъёог багтаасан байдаг.

ХЗДХЯ болон ЗТХЯ-ны хуульчидтай хэлэлцэн, зөвшилцсөний дагуу 2010 оны ИНД-1 “Тодорхойлолт ба товчлол”-ыг “ИНД-ийн нэр томъёоны тайлбар” хэлбэрээр шинэчлэн боловсруулсан ИНД-ийн нэр томъёоны тайлбар нь шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулсан ИНД-үүдэд орсон, 2010 оноос хойш хүлээгдэж байгаа нэмэлт, өөрчлөлтүүдийг тусган, орчуулга, найруулгын алдааг засаж залруулснаас гадна үндэслэлгүйгээр хассан, орхигдуулсан, өөрчилсөн нэр томъёог залруулан сайжруулсан хувилбар тул хэрэглэгчдэд илүү ойлгомжтой, үнэн зөв баримт бичиг болно.

ОУИНБ-ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, 2000 оноос жишиг болгон ашиглаж байгаа Шинэ-Зеланд улсын ИНД Part-1 “Товчлол болон тодорхойлолт” нь нийт 56 удаа буюу жилд 2-3 удаа өөрчлөгдөн боловсронгуй болж байдаг бол бид ИНД-д 10 жилд арай ядан 1 удаа өөрчлөлт хийж байгаа нь иргэний нисэхийн салбарын хөгжлийг боймолсон үйлдэл болж байна.

ИНД-ийн нэр томъёоны тайлбар батлагдахгүй удаж байгаагаас шалтгаалан төрийн эрх зүйн бусад баримт бичгүүд нэр томъёоны хувьд Сайдын баталсан ИНД-ээс зөрүүтэй батлагдаж байгаа нь тодорхой бус байдлыг бий болгож байна. Үүний тод жишээ нь, 2019 онд батлагдсан ИНД-100, ИНД-108, ИНД-109, ИНД-140-ээс зөрүүтэй нэр томъёотой батлагдсан Агаарын тээврийг хялбаршуулах журам болон Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам юм.